



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Насан туршийн боловсролын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2021/154/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaal@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл



## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15



## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

А021-02-23 № 131.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ДОРНОД АЙМГИЙН НАСАН ТУРШИЙН  
БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН ДАРГА  
А.НАНСАЛМАА ТАНАА

### Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Насан туршийн боловсролын төв нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 88,9 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020040



### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<b>0.00</b>	<b>0.00</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	0.00
351	Түүхий эд материал	0.00	0.00
354	Хангамжийн материал	0.00	0.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<b>0.00</b>	<b>0.00</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	0.00
392	Биет хөрөнгө	0.00	0.00
393	Биет бус хөрөнгө	0.00	0.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<b>0.00</b>	<b>0.00</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<b>0.00</b>	<b>0.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<b>0.00</b>	<b>0.00</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<b>0.00</b>	<b>0.00</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<b>10,000,000.00</b>	<b>11,200,000.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>10,000,000.00</b>	<b>11,200,000.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,000,000.00	11,200,000.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10,000,000.00	11,200,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<b>10,000,000.00</b>	<b>11,200,000.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>10,000,000.00</b>	<b>11,200,000.00</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00	10,658,553.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,888,900.00	9,867,400.00
210101	Үндсэн цалин	8,888,900.00	9,300,985.61
210102	Нэмэгдэл		566,414.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,111,100.00	791,153.00
210201	Тэтгэврийн даатгал	755,600.00	543,515.00
210202	Тэтгэмжийн даатгал	71,100.00	49,588.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	88,900.00	61,909.00
210204	Ажилгүйдлийн даатгал	17,700.00	12,322.00
210205	Эрүүл мэндийн даатгал	177,800.00	123,819.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	541,447.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	541,447.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		541,447.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-



3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	-
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	-

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	10,000,000.00	11,200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,000,000.00	11,200,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,000,000.00	11,200,000.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10,000,000.00	11,200,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,000,000.00	11,200,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.00	11,200,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00	10,658,553.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,888,900.00	9,867,400.00
210101	Үндсэн цалин	8,888,900.00	9,300,985.61
210102	Нэмэгдэл	-	566,414.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,111,100.00	791,153.00
210201	Тэтгэврийн даатгал	755,600.00	543,515.00
210202	Тэтгэмжийн даатгал	71,100.00	49,588.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	88,900.00	61,909.00
210204	Ажилгүйдлийн даатгал	17,700.00	12,322.00
210205	Эрүүл мэндийн даатгал	177,800.00	123,819.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	541,447.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	541,447.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	541,447.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00



C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн					0.00
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	10000000.00	10000000.00	11200000.00	10658553.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	10000000.00	10000000.00	11200000.00	10658553.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	10000000.00	10000000.00	11200000.00	10658553.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	8888900.00	8888900.00	9867400.00	9867400.00
210101	Үндсэн цалин	8888900.00	8888900.00	9700800.00	9300985.61
210102	Нэмэгдэл			166600.00	566414.39
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1111100.00	1111100.00	1332600.00	791153.00
210201	Тэтгэврийн даатгал	755600.00	755600.00	937300.00	543515.00
210202	Тэтгэмжийн даатгал	71100.00	71100.00	79200.00	49588.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	88900.00	88900.00	98800.00	61909.00
210204	Ажилгүйдлийн даатгал	29800.00	29800.00	19600.00	12322.00
210205	Эрүүл мэндийн даатгал	165700.00	165700.00	197700.00	123819.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	10000000.00	10000000.00	11200000.00	11200000.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	0.00	0.00	0.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих				
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	10000000.00	10000000.00	11200000.00	11200000.00
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	0.00	0.00	0.00	0.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	0.00	0.00	0.00	0.00
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	0.00	0.00	0.00	0.00
14	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	0.00	0.00	0.00
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	0.00	0.00	0.00	0.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	1.00	1.00	1.00	1.00
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	25.00	25.00	25.00	25.00
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	25.00	25.00	25.00	25.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан



Нэмэлт дансаар гүйлгээ хийдэггүй.

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Насан туршийн боловсролын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга А.Нансалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-аас 2021 оны 02 дугаар сарын 20-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Насан туршийн боловсрол, амьдрах ухаан, эрүүл мэнд, гоо зүйн хүмүүжил, авьяасын нээх чиглэлийн дагуу сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Баянтүмэн сумын ИТХ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн санхүү хяналт дотоод аудитын албанаас 2020 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Насан туршийн боловсролын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 10,000.0 мянган төгрөгөөс тооцон 200.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 224.0 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Насан туршийн боловсролын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос өөрчлөгдөөгүй, өөрийн гэсэн хөрөнгө байхгүй боловсрол, соёл урлагийн газарт үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	0	0	0
Үндсэн хөрөнгө	0	0	0
Элэгдэл	0	0	0
<b>Нийт хөрөнгө</b>	0	0	0
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0	0	0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	0	0	0

Насан туршийн боловсролын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,200.0 мянган төгрөгөөр буюу 12 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орон нутгийн төсвийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг нэмснээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 658,6 мянган төгрөгөөр буюу 6,5 хувиар өссөн байна. Цалин хөлсний 358,6 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газраас цалин хөлс нэмснээс шалтгаалжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 11,200.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 11,200.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан байна. Энэ нь цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 11,200.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан байна.



Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 11,200.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 10,658.6 мянган төгрөгийг зарцуулж 541.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,658.6 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь Цалин хөлс, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 541,4.3 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Нэмэлт санхүүжилтээр гүйлгээ хийгдээгүй байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 139 мэдээллээс хугацаандаа оруулсан 128 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 9 мэдээлэл байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 11,200.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал гараагүй тул залруулга хийгдээгүй болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 11,200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Насан туршийн боловсролын төв нь 11,200.0 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд хоцроон байршуулсан нь Шилэн дансны 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор", 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт", 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.7 дах "байгууллагын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлт" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй болно.



### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Худалдан авалтын татварын е-баримтыг харилцагч байгууллагаас заавал гаргуулж авч баримтад бүрэн хавсаргасныг шалгана.

#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Насан туршийн боловсролын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/154/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Насан туршийн боловсролын төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
2	Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг тулган шалгахад нийт 139 мэдээ байршуулах ёстойгоос тухайн жилийн төсөв, хөрөнгө оруулалт, орон тооны мэдээлэл зэрэг 9 мэдээллийг хоцроон мэдээлсэн байна	11,200.0		Дарга	А.Нансалмаа
<b>ДҮН</b>		<b>11,200.0</b>			